


ЦӨЛЖИЛТ, ГАЗРЫН ДОРОЙТОЛ БА УРГАМЛАН НӨМРӨГ

Дэлхийн хуурай газрын 41%-ийг эзлэн оршиж дэлхийн хүн амын 38%-ийг тэжээн тэтгэж буй хуурай болон хагас хуурай бүс нутагт тулгамдаж буй ноцтой аюул бол цөлжилт, газрын доройтол юм^{1,2}. Монгол орны хувьд нийт нутаг дэвсгэрийн 80-90 хувь нь цөлжилт, газрын доройтолд өртөх магадлалтай, өндөр эрсдэлтэй нутаг хэмээн үздэг³.

Газрын доройтол гэдэг бол хөрсний үржил шимт чанар буурах, алдагдах явдал бөгөөд хөрсийг хамгаалж байдаг хамгийн чухал хоёр хүчин зүйл нь хөрсний чийг болон ургамлан бүрхэвч гэж тодорхойлж болно. Ургамлан бүрхэвч нь хөрсийг ус болон салхиар элэгдэх үйл явцаас хамгаалахаас гадна түүний биологийн олон янз байдлыг хадгалан хамгаалж, түүнд явагдах процессууд, бодисын эргэлтэд оролцож байдаг билээ.



Зураг 1. Газрын доройтол хүргэх хүчин зүйлс болон үйл явц

Ургамлан нөмрөг доройтвол ямар үр дүнд хүрэх вэ?

Байгаль болон хүний хүчин зүйлийн нөлөөгөөр ургамлан бүлгэмдэл доройтох нь хөрс ус болон салхиар элэгдэх эрчмийг нэмэгдүүлж түүнд хуурайшилт явагдах үндэс болно. Ингэснээр хөрсний үржил шим, түүний бүтээгдэхүүн, олон янз байдал алдагдаж цаашлаад хөрсний элэгдэл, эвдрэлийг улам эрчимжүүлэхээс гадна экосистемээс хүртэх үйлчилгээг бууруулдаг. Цаашлаад экосистем өөрөө нөхөн сэргэх чадвар алдагдаж байгалийн аюулт үзэгдэлд эмзэг болох буюу гангийн давтагдал нэмэгдэх, хур тунадасны хуваарилалт болон хэлбэр өөрчлөгдөж аадар борооны давтамж нэмэгдэх зэрэг өөрчлөлтүүд ажиглагддаг байна. Үүнтэй холбоотойгоор биологийн олон янз байдал алдагдах бөгөөд үүн дээр хүний үйл ажиллагаа, уур амьсгалын өөрчлөлт нэмэгдэж эргэж буцалтгүй цөлжсөн төлөв байдалд шилжихэд хүргэдэг.

¹ GLP (2005) Science Plan and Implementation Strategy.

² Huang, J., Zhang, G., Zhang, Y., Guan, X., Wei, Y. and Guo, R., 2020. Global desertification vulnerability to climate change and human activities. Land Degradation & Development

³ Мандах Н., Даш Д. бусад. 2013. Монгол орны цөлжилтийн атлас. УБ. 9,91 х.

Түүнд нөлөөлөгч хүчин зүйлс

Хүний үйл ажиллагааны улмаас ургамлан нөмрөг доройтоход хүргэж буй олон хүчин зүйл байгаагаас бэлчээрийн даац хэтрэх болон тариалангийн талбайг нэмэгдүүлэх нь хуурай бүс нутагт газрын доройтол явагдаж буй шалтгааны 70%-ийг эзэлж байна⁴.



Зураг 2. Мал бэлчээрлэлтийн нөлөө их болон харьцангуй бага нутаг дах ургамлан нөмрөгийн ялгаа (Сэлэнгэ аймаг)

Монгол орны хувьд байгалийн бэлчээр нь нийт нутаг дэвсгэрийн 72.4%, хөдөө аж ахуйн эдэлбэр газрын 99.3%-ийг тус тус эзэлдэг⁵. Үндэсний статистикийн хорооноос гаргасан мэдээгээр малын тоо толгой 1970 оноос хойш тасралтгүй өссөн бөгөөд 2018 оны байдлаар 71 саяд хүрч 1970 онтой харьцуулахад 3 дахин ихэссэн байна. Төрөл бүрийн мал ургамлын газар дээрх хэсгийг таслан идэх, үндсээр сугалах, гишгэж давтах зэрэг шууд нөлөө үзүүлэхээс гадна хөрсний физик, химийн чанарт дам нөлөөлж байдаг⁶.

Бэлчээрийн хэт ашиглалт манай орны хувьд тулгарч буй томоохон асуудал бөгөөд ургамлан нөмрөгийг хамгаалах, зөв зохистой ашиглах менежмент боловсруулах, хэрэгжүүлэх шаардлага манай орны хувьд нэн тэргүүний асуудал болж байна.

Д.Отгонцэцэг

И-мэйл: otgondn@gmail.com

Газарзүй & Геоэкологийн хүрээлэн, Цөлжилтийн судалгааны салбар

4 Sujith Ravi, David D. Breshears, Travis E. Huxman, Paolo D'Odorico. 2009. Land degradation in drylands: Interactions among hydrologic–aeolian erosion and vegetation dynamics. *Geomorphology* 116.

⁵ Д.Булгамаа., С.Сүмжидмаа., Б.Бэстелмейр., У.Будбаатар. 2018. Монгол орны бэлчээрийн төлөв байдлын үндэсний тайлан: Хоёр дахь үнэлгээ. ШХА-н Ногоон алт-малын эрүүл мэнд төсөл; Монголын Бэлчээр Ашиглагчдын Нэгдсэн Холбоо. Улаанбаатар хот

⁶ Чогний, О., 2001. Монголын ойт хээр, хээрийн бүсийн нүүдлээр ашиглагдсан бэлчээрийн өөрчлөгдөх, сэргэх онцлог. УБ